

“Дулаан Шийдэл II” төслийн санхүүжүүлэгч байгууллагууд:

switchasia



Funded by
the European Union

FONDATION
LOGEMENT

GLOBAL ALLIANCE
FOR GREEN AND
GENDER ACTION

AFD



ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ БА САНХҮҮЖИЛТЫН МЕХАНИЗМ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛАВ



“Дулаан Шийдэл II” төслийн санхүүжүүлэгч байгууллагууд:

geres
ACTING FOR
CLIMATE
SOLIDARITY



MNCA
MONGOLIAN NATIONAL
CONSTRUCTION ASSOCIATION

MGFC



MONGOLIAN
WOMEN'S
FUND



Энэхүү гарын авлагыг “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулан гаргав. Энэхүү гарын авлагад дурдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг “Дулаан Шийдэл II” төсөл бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

Хэвлэлийн эх: Жэрэс ОУТББ, Улаанбаатар Хот, 2026 он

“Дулаан шийдэл” төсөл нь 2 үе шаттайгаар 2018-2022, 2022-2026 онуудад Улаанбаатар хотын гэр хорооллын амины орон сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаснаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой үйл ажиллагаагаа явуулав. Дулаан Шийдэл II төсөл нь Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөр, Орон Сууцжуулалтын сан, ГАГГА сан болон Францийн хөгжлийн агентлаг зэрэг байгууллагуудын санхүүжилт дэмжлэгтэйгээр хэрэгжив.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	
	Жэрэс Олон Улсын ТББ (Жэрэс ОУТББ) нь Бүгд Найрамдах Франц Улсад төвтэй 1976 онд байгуулагдсан ба эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр мэргэшин ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол улсад 2010 оноос хойш Төлөөлөгчийн газраа байгуулан эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
	Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв (БЭХХТ): ШУТИС -ийн Барилга Архитектурын Сургуулийн харьяа, Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй техник технологийг нэвтрүүлэх зорилготойгоор сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төв.
	Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ (МБУА ТББ): 2009 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй барилгын салбар дахь хамгийн том нэгдэл бүхий гишүүддээ болон нийгэмд үйлчилдэг, үйл ажиллагаа нь төрөөс хараат бус, ашгийн бус байгууллага.
	Монголын эмэгтэйчүүдийн сан ТББ (МОНЭС): 2000 онд үүсгэн байгуулагдсан, төрөөс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, нийтийн сан бөгөөд эмэгтэйчүүд, охидыг хүчирхэгжүүлж, нийгмийн өөрчлөлт бий болгохын төлөө эмэгтэйчүүдийн ТББ, орон нутгийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлдэг байгууллага.
	Монголын ногоон санхүүгийн корпорац (МНСК): Үндэсний ногоон санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг нэгдсэн бодлого, стандартаар хангаж, хөнгөлөлттэй нөхцөлтэй ногоон зээлээр санхүүжүүлэх зорилтын хүрээнд 2014 онд байгуулагдсан.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН АМИНЫ ОРОН СУУЦНЫ ДУЛААЛГЫН ШИЙДЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ ГАРЫН АВЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?

Санхүүгийн байгууллагуудад зориулсан амины орон сууцны дулаалга, бусад шийдлийг танилцуулсан энэхүү гарын авлагыг “Дулаан Шийдэл” төслийг хэрэгжүүлсэн туршлага, мэдээлэл, судалгаа, оролцогч талуудын санал, зөвлөмжид үндэслэн боловсруулсан бөгөөд дараах мэдээллийг нэг дор авах боломжтой:

1. Дулаалга ба ногоон санхүүжилтийн боломжууд 6
2. Дулаалгын зээл олгох аргачлал 16
3. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төрлүүд 28
4. Холбогдох судалгааны үр дүн 32
5. Холбоо барих мэдээлэл 36

Энэхүү гарын авлага болон холбогдох хавсралтуудыг dulaalga.mn веб сайтад байршуулсан бөгөөд хэвлэмэл болон цахим хэлбэрээр хөгжүүлсэн болно. Та өөрт хамгийн тохиромжтой хувилбарыг сонгон ашиглах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг dulaalga.mn цахим хуудасны “Амины Орон Сууцны Дулаалгын Шийдэл” цэсийн Санхүүгийн байгууллагад зориулсан цэсээс авах боломжтой.



dulaalga.mn “Амины Орон Сууцны Дулаалгын Шийдэл” → Санхүүгийн байгууллагад

Цэс рүү орж дулаалгын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч гарын авлагын онлайн хувилбарыг үзэх боломжтой.



ГАРЫН АВЛАГЫН ТОВЧ ХУРААНГУЙ



3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, АМИНЫ ОРОН СУУЦНЫ ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ БА САНХҮҮЖИЛТЫН МЕХАНИЗМ



ДУЛААЛГА БА НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖУУД

Дулаалга нь хүлэмжийн хийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах бодит нөлөөтэй тул ногоон санхүүжилтын зорилтот бүрэн хамрагддаг. Үүний хүрээнд олон улсын болон үндэсний түвшний санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй эх үүсвэр, баталгаа, буцалтгүй тусламж, техникийн дэмжлэг авах боломж харьцангуй өндөр байдаг. 1.1-р бүлгээс дулаалга нь санхүүгийн байгууллагад ямар ач холбогдолтой талаар мэдээлэл аваарай.

1

1

ХОТУУДЫН АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭР БА АМИНЫ ОРОН СУУЦ БОЛОН ГЭР СУУЦАНД АМЬДАРДАГ АЙЛ ӨРХҮҮДИЙН ТОО

Улаанбаатар хотын агаарын бохирдлын дийлэнх буюу **55,6** хувийг гэр хорооллын айл өрхийн зуухны утаа бүрдүүлдэг. Нийслэлийн нийт өрхийн 50.2% буюу **233,580** нь инженерийн дэд бүтэцгүй гэр, байшинд амьдарч байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 1.2 болон 1.3-р бүлгүүдээс авна уу.



1

ДУЛААЛГА ЯАГААД ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НОГООН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

Дулаалга нь дараах нөхцөлийг хангадаг тул ногоон зээлд хамрагдах бүрэн боломжтой. Үүнд:

- Эрчим хүчний хэмнэлт бий болгож, дулаан алдагдлыг бууруулна
- Ногоон зээлийн шалгуур, шаардлагад нийцнэ
- Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж, хүлэмжийн хийг бууруулна
- Техникийн үндэслэлтэй, үр дүн нь хэмжигдэх боломжтой. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүйг 1.4-р бүлгээс харна уу.



НОГООН ЗЭЭЛИЙН ОЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД БАНК, ББСБ-ЫН ЗЭЭЛИЙН АЖИЛТНУУДЫН ХУВЬ

Ногоон зээлийн олголтыг нэмэгдүүлэхэд зээлийн ажилтнууд энгийн ойлгомжтой тайлбар өгөх, зорилтот хэрэглэгчийг зөв тодорхойлох, тооцоо жишээгээр итгэлцэл бий болгох, шийдвэрийн явцыг шуурхай удирдах, бага хүү урт хугацааны давуу талыг онцлох, байгаль орчин нийгмийн ач холбогдлыг ойлгуулах замаар бодит хувь нэмэр оруулна. Энэ талаарх дэлгэрэнгүй зөвлөмжийг 1.5-р бүлгээс харна уу.



2

1



ДУЛААЛГЫН ЗЭЭЛ ОЛГОХ АРГАЧЛАЛ

Дулаан Шийдэл төслийн хүрээнд иргэдэд амины орон сууцаа дулаалуулах нэг цэгийн үйлчилгээ санал болгож, зөвлөгөө, гүйцэтгэл, эрчим хүчний гэрчилгээ болон ногоон зээлийг уялдуулан банк, ББСБ-тай хамтран ажиллаж ирсэн туршлагатай. 2-р бүлгээс энэхүү дулаалгын загвар болон Банк, ББСБ-уудын оролцоо хэрхэн явагдсаныг харах боломжтой ба энэхүү загварт үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэн ажиллах боломжтой.

ГАРЫН АВЛАГЫН ТОВЧ ХУРААНГУЙ



3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, АМИНЫ ОРОН СУУЦНЫ ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ БА САНХҮҮЖИЛТЫН МЕХАНИЗМ



ДУЛААЛГЫН НОГООН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ СТАНДАРТ ДУЛААЛГЫН ТӨРЛҮҮД

Арилжааны банкууд эрчим хүчний хэрэглээг **20%-иас** дээш бууруулах дулаалгын шийдэлд ногоон зээл олгодог. Дээврийн 15–20 см, ханын дулаалга, эсвэл хослуулсан арга замаар энэхүү шаардлагыг хангах боломжтой. Дэлгэрэнгүйг 2.2-р бүлгээс үзнэ үү.

2

3

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦ

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэдэг нь Монгол орны эрс тэс уур амьсгалын нөхцөлд дотор орчны тав тух, эрүүл ахуйг хадгалах явцдаа эрчим хүчний хэрэглээг зохимжит хэмжээнд зарцуулахаар төлөвлөгдсөн амины орон сууцны бүтэц юм. 3-р бүлгээс энэхүү амины орон сууцны зарчмуудын талаарх ойлголтыг аваарай.



ТЭГ ЗАРЦУУЛАЛТТАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ СУУЦ

3

Тэг зарцуулалттай эрчим хүчний сууц гэдэг нь тухайн барилга нь жилийн турш хэрэглэдэг нийт эрчим хүчний хэмжээг өөрөө үйлдвэрлэж, гаднаас нэмэлт эрчим хүч авахгүйгээр өөрийн хэрэгцээг бүрэн хангах чадвартай сууц юм. Энэхүү сууцны дэлгэрэнгүй мэдээлэл, зураг төслийг татаж авах QR кодыг 3-р бүлгээс харна уу.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ДУЛААЛГЫН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭХ НЬ СУДАЛГАА, 2025 ОН

5

4

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь 24-36 сарын хугацаатай, 10 сая төгрөг хүртэлх зээлийг сарын 0,5-2,5%-ийн хүүтэйгээр барьцаа, урьдчилгаа бага шаардах нөхцөлөөр авч амины орон сууцаа дулаалах сонирхолтой байна. Дэлгэрэнгүйг 4.3-р бүлгээс харна уу



ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

5-р бүлэгт “Дулаан шийдэл” төслийн дулаалгын технологиор сургагдаж, чадавхжсан гүйцэтгэгчдийн холбоо барих мэдээлэл, дулаалгын материал нийлүүлэгчид, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гүйцэтгэгчид болон эрчим хүчний аудиторуудын мэдээллийг онцоллоо.

ДУЛААЛГА БА НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖУУД



1.1 ДУЛААЛГА, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ НЬ БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээрх үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн, урт хугацаанд эдийн засгийн болон байгаль орчны давхар өгөөж бий болгодог хөрөнгө оруулалтын чухал чиглэл юм. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр эрчим хүчний хэрэглээ болон зардал буурч, зээлдэгчдийн төлбөрийн чадвар сайжрах нөхцөл бүрддэг. Энэхүү салбар нь **хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, агаарын бохирдлыг багасгах** бодит нөлөөтэй тул ногоон санхүүжилтийн зорилтот чиглэлд бүрэн хамрагддаг. Үүний хүрээнд олон улсын болон үндэсний түвшний санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй эх үүсвэр, баталгаа, буцалтгүй тусламж, техникийн дэмжлэг авах боломж харьцангуй өндөр байдаг нь банк, санхүүгийн байгууллагуудын хувьд санхүүжилтийн өртгийг бууруулах давуу тал болдог.

Мөн дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн төслүүд нь **техникийн хувьд харьцангуй стандартчилагдсан, үр дүн нь хэмжигдэх боломжтой** (эрчим хүчний хэмнэлт, зардлын бууралт), ашиглалтын хугацаа урт, эрсдэл багатайд тооцогддог. Энэ нь зээлийн багцыг төрөлжүүлэх, ESG шаардлагыг хангах, ногоон зээл болон ногоон бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой. Иймд дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн салбарт чиглэсэн санхүүжилтийг хөгжүүлэх нь **банк, санхүүгийн байгууллагуудын тогтвортой санхүүжилтийн стратегийг хэрэгжүүлэх**, зах зээлийн шинэ сегментэд нэвтрэх, урт хугацаанд тогтвортой өгөөж хүртэх боломжийг бүрдүүлнэ.



1.2 ХОТУУДЫН АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭР

Монгол орны өвлийн хүйтэн нөхцөлд дулаан алдагдал ихтэй барилга, сууц нь дулааны хэрэглээг нэмэгдүүлж, утаа болон агаарын бохирдлыг үүсгэх гол хүчин зүйлсийн нэг болсоор байна. Эдгээр сөрөг үр дагаврыг бууруулах хамгийн үр дүнтэй арга нь чанартай дулаалгын материал ашиглан барилгын бүх хэсгийг стандартын дагуу дулаалах явдал юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг Нийслэл болон Авто тээврийн үндэсний төвөөс 2024 онд дараах байдлаар тооцож гаргасан.

АГААРЫН БОХИРДЛЫН ГОЛ ЭХ ҮҮСВЭРҮҮД



Дээрх тоон үзүүлэлтээс харахад Улаанбаатар хотын агаарын бохирдлын ихэнх хувь нь гэр хороололд амьдарч буй айл өрхийн зуухны яндангаас гарч буй утаанаас үүдэлтэй байна. Улсын хэмжээнд нийт 352,892 зуух тоологдсон бөгөөд жилдээ 530,943 тонн түүхий нүүрс, 476,688 тн сайжруулсан түлш хэрэглэж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан 2024 оны тайланд “Агаарын бохирдлын эх үүсвэрийн 2023-2024 оны улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан”-д агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хийж дараах үр дүнг гаргасан байна.

Монгол улсын хэмжээнд ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай 352892зуух, 15-100 кВт хүртэл хүчин чадалтай усан халаалтын 4521 зуух, 100-4200 кВт хүртэл хүчин чадалтай 1173 зуух, 4200кВт-аас дээш хүчин чадалтай 43 байгууламжийн 126 зуух тус тус бүртгэгдсэн байна.

Эдгээр зууханд төрөл бүрийн түлш шатааж агаарын бохирдол үүсгэдэг гол суурин эх үүсвэр болж байгаа зуух нийтдээ 358,712 бүртгэгдсэн ба нийт 11,038,633.8 тонн түүхий нүүрс, 1,220,678м3 орчим мод тус тус жилд хэрэглэж байна. Авто тээврийн хэрэгсэл улсын хэмжээнд

1,194,200 бүртгэгдсэн байна.

Доорх зурагт харуулснаар айл өрхүүдийн хэрэглээнд жил бүр 530,943 тонн түүрс, 476,688 тонн сайжруулсан түлш, 671,373 тонн түлээ, 122,095 тонн аргал зэргийг байшин, гэр сууцаа халаах ахуйн хэрэгцээнд хэрэглэж байна. Байшин сууцаа дулаалж, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх замаар эдгээр түлшний хэрэгцээг багадаа 50% хүртэл бууруулж хэмнэлт бий болгох боломжтой.

УЛСЫН ХЭМЖЭЭНД АЙЛ ӨРХҮҮДИЙН ХЭРЭГЛЭЖ БҮЙ ГОЛЛОХ ТҮЛШНИЙ ТӨРӨЛ ТОО ХЭМЖЭЭ (ЖИЛД)



1.3 АМИНЫ ОРОН СУУЦ БОЛОН ГЭР СУУЦАНД АМЬДАРДАГ АЙЛ ӨРХҮҮДИЙН ТОО

Манай улсын нийт 983,485 өрхийн 40 орчим хувь буюу 385,290 өрх нь инженерийн дэд бүтцийн шаардлага хангасан орон сууцанд амьдардаг бол 21.7 хувь буюу 213,652 өрх нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин сууцанд, 38.2 хувь буюу 375,691 нь гэр сууцанд тус тус амьдарч байна.

БАЙШИН БОЛОН ГЭР СУУЦАНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО



Нийслэлийн статистикийн газар 2024 оны 01 сарын 01 байдлаар

	Өрхийн тоо	Гэр сууц	Байшин сууц	Орон сууц	Хаус
Улс	983,485	375,691	213,652	385,290	8,851
Нийслэл	465,059	88,642	113,709	258,408	4,158
Орон нутаг	518,426	272,448	85,416	154,036	2,351

Үндэсний статистикийн хороо 2023 оны байдлаар

Нийслэл Улаанбаатар хотын 50.2 хувь буюу 233,580 өрх нь гэр хорооллын бүсэд инженерийн дэд бүтцийн хангамжгүй байшин болон гэр сууцанд амьдарч байна.

1.4 ДУЛААЛГА ЯАГААД ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ НОГООН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

Дулаалга нь эрчим хүчний хэмнэлттэй ногоон зээлд хамрагдах стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төрөлд тооцогддог. Учир нь дулаалгын шийдэл нь эрчим хүчний хэмнэлт, эдийн засгийн үр ашиг, байгаль орчны эерэг нөлөө, техникийн үндэслэл зэрэг олон шалгуурыг нэгэн зэрэг хангадаг.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ БА ДУЛААН АЛДАГДЛЫН БУУРАЛТ

Барилгын дулаалгыг сайжруулснаар халаалтын зориулалттай эрчим хүчний хэрэглээ дунджаар 30–60 хувиар буурах боломжтой. Үүний үр дүнд түлш, цахилгаан, нүүрс, модны хэрэглээ багасаж, өрхийн болон аж ахуйн нэгжийн эрчим хүчний зардал бодитоор буурна. Монгол Улсын гэр хорооллын амины орон сууцнуудын дулаан алдагдал харьцангуй өндөр байдаг тул дулаалга нь эрчим хүчний хэмнэлт бий болгох хамгийн үр дүнтэй шийдлүүдийн нэг гэж үздэг.

НОГООН ЗЭЭЛИЙН ШАЛГУУРТ НИЙЦЭХ БАЙДАЛ

Ногоон зээл нь эрчим хүчний хэрэглээг бууруулах, CO₂ ялгарлыг багасгах, байгаль орчинд ээлтэй шийдлүүдийг дэмжих зорилготой. Энэ хүрээнд дулаалга нь ногоон зээлийн үндсэн шалгуурт бүрэн нийцдэг. Тухайлбал, “BestGER” зэрэг эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны шалгуурт дулаалгын шийдэл зайлшгүй багтдаг бөгөөд ийм төрлийн хөрөнгө оруулалт нь хүүгийн татаастай, урт хугацаатай зээлд хамрагдах, мөн татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал эдлэх боломжийг бүрдүүлдэг.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Дулаалгын ажлыг хэрэгжүүлснээр агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах боломжтой. Монгол Улсын УИХ-аас баталсан бодлогын баримт бичгүүдэд дулаалгыг агаарын бохирдлыг 50–80 хувь хүртэл бууруулах гол арга хэмжээний нэг гэж тодорхойлсон байдаг. Мөн “Дулаанбаатар” аяны хүрээнд 300,000 өрхийн дулаалгын ажлыг ногоон зээлээр санхүүжүүлэх зорилт дэвшүүлсэн нь энэхүү чиглэлийн нийгэм, байгаль орчны ач холбогдлыг харуулж байна.

ТЕХНИКИЙН ҮНДЭСЛЭЛ БА СТАНДАРТ

EPS, базальт чулуун хөвөн, полиуретан хөөс зэрэг дулаалгын материалууд нь барилгын дулаан дамжуулалтын коэффициент (U-value)-ийг бууруулж, эрчим хүчний алдагдлыг хязгаарладаг. Эдгээр материал, шийдлүүдийг MNS EN ISO 6946:2016, MNS 5636:2006 зэрэг холбогдох стандартын дагуу хэрэгжүүлсэн тохиолдолд техникийн хувьд баталгаатай гэж үзнэ. Ийм техникийн үзүүлэлтүүд нь ногоон барилга, ногоон санхүүжилтийн шалгуурт шууд хамаардаг.

САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ДЭМЖЛЭГ

Монгол банк, Засгийн газар болон олон улсын байгууллагууд хамтран ногоон зээлийн тусгай журам, хөнгөлөлттэй нөхцөл, зээлийн баталгааны механизм боловсруулж байна. Үүний хүрээнд амины орон сууцны дулаалгын ажилд зориулсан тусгай санхүүжилтийн бүтээгдэхүүнүүд бий болж, иргэдийн ногоон зээлд хамрагдах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.



Зураг. Ногоон зээлийн зарчим

1.5 НОГООН ЗЭЭЛИЙН ОЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД БАНК, ББСБ-ЫН ЗЭЭЛИЙН АЖИЛТНУУД ХЭРХЭН ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

Ногоон зээлийн амжилт нь зөвхөн бодлого, бүтээгдэхүүнээс бус, зээлийн ажилтнуудын өдөр тутмын харилцаа, зөвлөх үйлчилгээ, шийдвэр гаргалтаас ихээхэн хамаардаг. Доорх чиглэлүүдээр зээлийн ажилтнууд бодитой хувь нэмэр оруулах боломжтой.



Зураг. Нээлттэй өдөрлөг, Дархан хот

НОГООН ЗЭЭЛИЙГ ЭНГИЙН, ОЙЛГОМЖТОЙГООР ТАНИУЛАХ

Зээлийн ажилтнууд ногоон зээлийн ойлголтыг техникийн нэр томьёо ашиглалгүй, үйлчлүүлэгчийн амьдралд үзүүлэх бодит ашиг тусад тулгуурлан тайлбарлах нь зээлийн эрэлтийг нэмэгдүүлнэ. Тухайлбал:

- Сарын халаалтын зардал 25–60% буурна
- Дулаалга хийлгэвэл зээлийн төлбөрийн тодорхой хэсгийг хэмнэлтээрээ нөхнө
- Хүйтэн хана, салхитай өрөөний асуудал алга болно гэх мэтээр.

ХЭРЭГЛЭГЧИЙГ ЗӨВ СЕГМЕНТЛЭЖ, ТОХИРСОН БҮТЭЭГДЭХҮҮН САНАЛ БОЛГОХ

Зээлийн ажилтнууд хэрэглэгчийн орлого, хэрэглээ, орон сууцны нөхцөл, халаалтын зардлыг харгалзан ногоон зээлийн тохиромжтой бүтээгдэхүүнийг санал болгох боломжтой. Ялангуяа

дараах айлууд зорилтот бүлэгт багтах боломжтой.

- Халаалтын зардал өндөр айл өрх
- Хуучин амины сууцтай өрх
- Бага орлоготой боловч хэмнэлт хэрэгтэй өрх
- Эрчим хүчний хэмнэлтийн талаар сонирхож буй иргэд

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ

Ногоон зээл нь зарим хэрэглэгчдийн хувьд шинэ ойлголт тул эргэлзээ, болгоомжлол үүсдэг. Зээлийн ажилтнууд эдгээр асуултад тооцоо, энгийн жишээ, бодит кейс ашиглан хариулах нь итгэлцлийг нэмэгдүүлнэ. Дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн шийдэл нь урт хугацаанд зардлыг хэрхэн бууруулж, зээлийн эргэн төлөлтөд хэрхэн эерэг нөлөө үзүүлэхийг ойлгуулах нь чухал.

ЗЭЭЛИЙН ШИЙДВЭРИЙН ҮЙЛ ЯВЦЫГ УДИРДАХ

Баримт бичгийн бүрдүүлэлт, шалгалт, шийдвэрийн явц удааших нь үйлчлүүлэгчийн сонирхлыг бууруулах эрсдэлтэй. Зээлийн ажилтнууд үйл явцыг ойлгомжтой тайлбарлаж, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авч, шийдвэр гарах хүртэл идэвхтэй холбоотой ажилласнаар ногоон зээлийн бодит олголтыг нэмэгдүүлэх боломжтой.

НОГООН ЗЭЭЛИЙН ДАВУУ ТАЛЫГ ТОГТМОЛ ОНЦОЛЖ СУРТАЛЧЛАХ

Зээлийн ажилтнууд ногоон зээлийн онцлог давуу талыг бусад зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулан тайлбарлах нь хэрэглэгчийн сонирхлыг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Харьцангуй бага хүү, урт хугацааны төлбөрийн нөхцөл
- Эрчим хүчний зардлыг бууруулснаар зээлийн эрсдэлийг багасгах боломж
- Стандартын дагуу чанартай гүйцэтгэл, төсөл хөтөлбөрийн дэмжлэг

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨГ ОЙЛГУУЛЖ, ХАМТЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Ногоон зээл нь зөвхөн санхүүгийн бүтээгдэхүүн бус, агаарын бохирдлыг бууруулах, амьдрах орчныг сайжруулах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах хэрэгсэл гэдгийг зээлийн ажилтнууд үйлчлүүлэгчид ойлгуулах боломжтой. Энэ нь ногоон зээлийг “сонголт” бус, “шаардлагатай шийдэл” болгон харуулахад тусалдаг.

1.6 ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ – БАНК, ББСБ-ЫН АЖИЛТНУУДАД

Тогтвортой хөгжил, агаарын бохирдол, эрчим хүчний хэмнэлт, дулаалга, мөн эдгээрийн ногоон зээлтэй уялдах талаар дэлгэрэнгүй мэдлэгтэй болохыг хүсвэл Дулаан Шийдэл төслийн хүрээнд банк болон ББСБ-ын ажилтнуудад зориулсан цахим сургалтын платформ-ыг хөгжүүлсэн бөгөөд төслийн веб сайтад үнэ төлбөргүй байршуулсан.

СУРГАЛТЫН ОНЦЛОГ

1. Богино, сонирхолтой видео хичээлүүд: Дулаалгын ногоон зээл, эрчим хүчний хэмнэлт, стандарт технологи, агаарын бохирдол, тогтвортой хөгжлийн мэдээллийг хамарна.
2. Мэдлэгийн баталгаажуулалт: Сургалтын эцэст богино хэмжээний тест бөглөх, амжилттай дуусгасны дараа цахим сертификат олгоно.
3. Багшгүй, уян хатан суралцах боломж: Шинээр ажилд орсон ажилтан болон мэдлэгээ сэргээх зорилготой ажилтнуудад тохиромжтой. Байгууллагын хэмжээнд олон ажилтанд санал болгож ашиглах боломжтой.
4. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн чиглэлд хувь нэмэр: Платформоор дамжуулан ажилтнууд танай банк, ББСБ-ын ногоон санхүүжилтийн зорилт, тогтвортой хөгжлийн стратеги, дулаалга, агаарын бохирдлын шийдлийг ойлгон ажилд хэрэгжүүлэх боломжтой.

www.dulaalga.mn → Амины Орон Сууцны Дулаалгын Шийдэл → Банк, Санхүүгийн байгууллага
Цахим сургалт цэс рүү орж аваарай.

02

ДУЛААЛГЫН ЗЭЭЛ ОЛГОХ АРГАЧЛАЛ

ДУЛААЛГЫН
ӨМНӨ



ДУЛААЛГЫН
ДАРАА



2.1 ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХӨГЖҮҮЛСЭН ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАР

Дулаан Шийдэл төслийн хүрээнд иргэн, айл өрх амины орон сууцаа дулаалуулахтай холбоотой бүх ажил, үйлчилгээг нэг дороос авах боломжтой, **нэг цэгийн үйлчилгээний зарчимд суурилсан дулаалгын механизм, зах зээлийн загвар** боловсруулсан. Энэхүү загварын хүрээнд дулаалгатай холбоотой зөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилт зэрэг үйлчилгээг уялдаа холбоотойгоор шийдэх боломж бүрдсэн. Төслийн хүрээнд хөгжүүлсэн стандарт дулаалгын технологийн дагуу мэргэшсэн баг айл өрхийн байшингийн дулаалгын ажлыг зөв технологиор, аюулгүй, чанартай гүйцэтгэх боломжтой. Ингэснээр иргэдийн зүгээс цаг хугацаа, зардлыг хэмнэхээс гадна эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ авах, дулаан алдагдлыг бууруулах, бодит хэмнэлт бий болгох зэрэг олон давуу тал үүсдэг.

Энэхүү зах зээлийн загварын хүрээнд ногоон зээл олголтын үе шатанд төслийн хугацаанд нийт **5 банк** (Хас банк, Хаан банк, Төрийн банк, Богд банк, Капитрон банк), **3 банк бус санхүүгийн байгууллага** (Транскапитал, Вишнфанд, Жи Эс Би Капитал)-тай хамтран ажилласан.

Дулаан Шийдэл төсөл нь **2018–2026 оны 4 дүгээр сарыг дуусталх хугацаанд** Улаанбаатар хот болон Дархан-Уул аймагт хэрэгжиж байна. Энэхүү дулаалгын зах зээлийн загвар нь төслийн хэрэгжилтийн хугацаанд хүчинтэй.

Банк болон банк бус санхүүгийн байгууллагууд уг дулаалгын зах зээлийн загварт үндэслэн **дулаалгад чиглэсэн ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, өргөжүүлэх боломжтой.**



Зураг. Зах зээлийн загвар

Алхам алхмаар: Хэрэглэгчид өөрсдийн санхүүгийн чадамждаа тохируулан шат дараалалтайгаар бүтэн дулаалга хийлгэх боломжтой.

СТАНДАРТ ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАРЫГ ДООРХ ДАРААЛЛААР ХӨГЖҮҮЛСЭН. ҮҮНД:

Захиалга өгөх

Иргэн, айл өрх нь “Дулаан шийдэл” төслийн дуудлагын төвийн 7505-2000 дугаарт холбогдон дулаан алдагдлын үнэлгээ хийлгэх захиалга өгнө.

Дулаан алдагдлын үнэлгээ, үнийн санал авах

Байшин, сууцны дулаан алдагдлын үнэлгээг дулаалгын зөвлөхөөр хийлгэж, шаардлагатай дулаалгын ажлын хэмжээ, үнийн саналыг авна.

Дулаалгын санхүүжилтээ шийдэх

Иргэд амины орон сууцаа дулаалахад шаардлагатай санхүүжилтийг дараах хоёр хэлбэрээр шийднэ. Үүнд:

- **Хувийн санхүүжилт:** Дулаалгын зардлыг иргэн өөрийн хөрөнгөөр бүрэн санхүүжүүлнэ.
- **Зээл авах:** Дулаалгын зөвлөхийн баталгаажуулсан дулаан алдагдлын үнэлгээний хуудсыг банк болон банк бус санхүүгийн байгууллагад үзүүлж, зээлийн хүсэлт гаргана.

Гэрээ байгуулах

Санхүүжилтээ шийдсэний дараа дулаалгын ажлыг гүйцэтгэх сургагдсан бригадтай гэрээ байгуулна.

Дулаалгын ажил гүйцэтгэх

Сургагдсан бригад дулаалгын ажлыг гүйцэтгэх бөгөөд дулаалгын үндсэн материалыг гэрээт ханган нийлүүлэгчдээс авч ашиглана.

Чанар, гүйцэтгэлийн хяналт

Дулаалгын ажлын чанар, гүйцэтгэлд мэргэжлийн инженерүүд дулаалгын ажлын актад үндэслэн хяналт хийнэ.

Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ

Дулаалгын ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа эрчим хүчний хэмнэлтийг тооцоолж, хөндлөнгийн аудитын дүгнэлт гарган, эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ олгоно.

ДУЛААЛГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАРТ БАНК, ББСБ-ЫН ОРОЛЦООНЫ ЭНГИЙН ҮЙЛ ЯВЦ

Энэхүү дулаалгын зах зээлийн загварт банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын

оролцоо нь харьцангуй энгийн, тодорхой үе шаттайгаар хэрэгждэг. Үүнд:

1. Төсөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах

Банк, ББСБ нь Дулаан Шийдэл төсөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.

2. Төслийн болон зээл олголтын сургалтад хамрагдах

Төслийн агуулга, стандарт дулаалгын технологи, зээлийн олголтын үе шат, баримт бичгийн шаардлагын талаар сургалт авна.

3. Зээлийн судалгаа хийх

Айл өрхөөс ирүүлсэн төслийн баталгаат дулаалгын үнэлгээний хуудас болон холбогдох баримт бичигт үндэслэн зээлийн судалгаа хийнэ.

4. Зээл олгох шийдвэрийн талаар төсөлд мэдэгдэх

Зээл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд тухайн шийдвэрийг төсөлд албан ёсоор мэдэгдэнэ.

5. Зээлийн гэрээ байгуулах

Банк, ББСБ нь зээлийн гэрээг айл өрхтэй шууд байгуулна.

6. Дулаалгын ажил гүйцэтгэсний дараах санхүүжилтийн мэдээлэл авах

Дулаалгын ажил дууссаны дараа төслөөс тухайн ажлын үнийн дүнг материал нийлүүлэгч болон дулаалгын ажил гүйцэтгэгчид шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл, холбогдох нэхэмжлэхийг хүлээн авна.

7. Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ авах


Дулаалгын ажлын чанар, баталгааг хангах зорилгоор эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээг төслийн хүрээнд авна.

1.3 ЗЭЭЛ СУДЛАХ

- Зурагт үзүүлсэн дулаалгын үнэлгээний хуудас нь зээл хүсэхэд шаардагдах анхан шатны баримт бичиг болно
- Уг дулаалгын үнэлгээний хуудас нь дулаалгын зөвлөхийн нэр бүхий тамгатай, үнийн саналын хүчинтэй хугацааны мөн тамгатай байна.
- Дулаалгын үнэлгээний хуудас 14 хоногийн хүчинтэй хугацаандаа байгаа эсэхийг хянана.

Зураг. Дулаан шийдэл төслийн хүрээнд ашигладаг "Дулаалгын үнэлгээний хуудас" ба банк болон ББСБ-уудын зээл судлах явцад анхаарах зүйлс

2.2 ДУЛААЛГЫН НОГООН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ СТАНДАРТ ДУЛААЛГЫН ТӨРЛҮҮД



2026 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагууд дулаалгын зээлийг дараах шалгуурын дагуу олгож байна. Үүнд:

АРИЛЖААНЫ БАНКНУУД:

Эрчим хүчний хэрэглээг 20 ба түүнээс дээш хувиар бууруулах боломжтой, стандартын шаардлага хангасан дулаалгын шийдэлд ногоон зээл олгож байна. Энэ нь дулаалгын ажил бодитой эрчим хүчний хэмнэлт бий болгож буйг тооцоо, үнэлгээгээр нотолсон байх шаардлагатай гэсэн үг юм.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД (ББСБ):

Эрчим хүчний хэмнэлтийн хувь хэмжээнд хатуу шаардлага тавихгүйгээр, айл өрхийн дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн стандарт дулаалгын ажлуудад зээл олгож байна. Ингэснээр орлого багатай, эрчим хүчний нарийвчилсан тооцоо гаргах боломж хязгаарлагдмал айл өрхүүдэд хүртээмжтэй шийдэл болж байна.


ДЭЭВРИЙН ДУЛААЛГА

Дулаан агаар дээш хөөрдөг тул дээврийн адрин хөндийг 20см зузаантай эрдэс хөвөнгөөр дулаалж ус, уур тусгаарлагчийг зөв байршуулах нь чухал юм. Дээврийн дулаалгын төрлүүд:

- Адрын хөндийн дулаалга
- Таазны дулаалга
- Налуу дээврийн дулаалга (дотор болон гадна талаас дулаалах)

ДУЛААЛГЫН МАТЕРИАЛЫН СОНГОЛТ:

- Эрдэс хөвөн
- Чулуун хөвөн болон шилэн хөвөн
- Хонины ноос



ТААЗНЫ ДУЛААЛГА

Эрчим хүчний хэмнэлт

30%



АНХААРАХ ЗҮЙЛС

1. Таазны дулаалга хийснээр орон зай багассан мэдрэмж төрнө
2. Дээврээс хурын ус ордоггүй байх (дусаал гоождоггүй байх)
3. Аюулгүй ажиллагааны орон зайг бүрдүүлж ажиллах
4. Гал дэмждэггүй материалаар өнгөлгөө хийгдэх шаардлагатай

НАЛУУ ДЭЭВРИЙН ДУЛААЛГА (ДОТОР БОЛОН ГАДНА ТАЛААС ДУЛААЛАХ)

Эрчим хүчний хэмнэлт

30%



АНХААРАХ ЗҮЙЛС

ДОТОР ТАЛААС НЬ ДУЛААХАД

1. Дээврээс хурын ус ордоггүй байх (дусаал гоождоггүй байх)
2. Аюулгүй ажиллагаагаа хангаж ажиллах
3. Гал дэмждэггүй материалаар өнгөлгөө хийгдэх шаардлагатай
4. Хэрвээ мансардны хэсэг босоо ханатай бол ханыг мөн дулаалах
5. Дулаалгыг агаарын үетэй хийх

ГАДНА ТАЛААС НЬ ДУЛААХАД

1. Хуучин дээврийн төмрийг дахин ашиглахгүй байх
2. Аюулгүй ажиллагааг хангаж ажиллах халтирахаас болгоомжлох
3. Яндан, агааржуулалтын хоолой гарсан нөхцөлд ус тусгаарлалтыг сайн хийх
4. Дулаалгыг агаарын үетэй хийх

ХАНЫН ДУЛААЛГА

Байшин сууцны ханыг гадна талаас нь ханын төрлөөс хамааруулан чулуун хөвөн, эрдэс хөвөн болон хөөсөнцөр хавтангаар дулаалдаг. Дотор талаас дулаалах нь чийг, хөгц үүсгэх эрсдэлтэй тул агаарын завсар, уур тусгаарлагчтай хамт хэрэглэх шаардлагатай.

а. Холболттой ханын дулаалга (Гадна болон дотроос дулаалах боломжтой)

Холболттой ханын дулаалга гэдэг нь ханын үндсэн материал нь ихэвчлэн блок, тоосго, бетон гэх мэт байх тохиолдолд дулаалгын материалын гадна талаас шавардлага, өнгөлгөө, заслыг шууд холбож /нааж/ хийдэг дулаалгын төрлүүдийг хэлнэ.

б. Агаар сэлгэлттэй ханын дулаалга (Гадна болон дотроос дулаалах)

Агаар сэлгэлттэй ханын дулаалга гэдэг нь ханын үндсэн материал ихэвчлэн модон бүтээцтэй ханын төрлүүдийг дулаалж, дулаалгын гадуур агаар сэлгэлтийн үе үүсгэж өнгөлгөө, заслал /фасад/-г хийх дулаалгын төрлүүдийг хэлнэ. Ингэснээр барилгын үндсэн модон бүтээц ба дулаалгын материалд агуулагдах чийгийг түгжихгүй, хөгц, өгөршил үүсэхээс хамгаалах, барилгын ашиглалтын хугацааг уртасгаж эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг талтай.


- Төмөр
- Хуванцар
- Өнгө сонголтоор

Мэргэжилтнүүд аливаа ханын дулаалгыг гадна талаас нь хийхийг зөвлөдөг бөгөөд тухайн барилгын онцлог, шаардлагад тохируулан гадна фасадыг сонгох нь зүйтэй.

ХОЛБОЛТТОЙ ХАНЫН ДУЛААЛГА (ГАДНА БОЛОН ДОТРООС ДУЛААЛАХ)

Эрчим хүчний хэмнэлт


35%



АГААР СЭЛГЭЛТТЭЙ ХАНЫН ДУЛААЛГА (ГАДНА БОЛОН ДОТРООС ДУЛААЛАХ)

Эрчим хүчний хэмнэлт

35%



АНХААРАХ ЗҮЙЛС

ГАДНА ТАЛААС ДУЛААЛАХАД

1. Гадна хана нь дулаалгын хавтан болон өнгөлгөөний шавардлага гэх мэт нэмэлт ачаалал (1 м² талбайд 35-аас 50 кг) авах боломжтой байх
2. Хэрэв гадна хана өнгөлгөө шавартай бол шаврын чанарыг шалгах /шаардлагатай бол нэмж шавардлага хийнэ/
3. Дээврийн өнгийлт хамгийн багадаа 20 см хүрэх
4. Ханын ачаалал даах чадварыг мэргэжлийн хүнээр үнэлүүлсэн байх
5. Гадна ханын зузаан 10см-ээс дээш байх
6. Гадна хана чийггүй байх.

ДОТОР ТАЛААС ДУЛААЛАХАД

1. Дулаалга хийснээр барилгын дотор талын ашигтай орон зай багасна
2. Байшингийн насжилт багасна
3. Дулаалга хийгдэж байх хугацаанд бригадыг ажиллах нөхцөлөөр хангаж сууцаа чөлөөлөх

АНХААРАХ ЗҮЙЛС

ГАДНА ТАЛААС ДУЛААЛАХАД

1. Гадна хана салангид хэсэггүй гадаргуу нь тэгш /хэвгий ±5мм бага/ байгаа эсэх;
2. Дээврийн өнгийлт хамгийн багадаа 20 см хүрч байгаа эсэх;
3. Гадна хана нь модон рам зангидах, дулаалга болон өнгөлгөөний хавтанг бэхлэх гэх мэт нэмэлт ачаалал (1 м² талбайд 50-аас 70 кг) авах боломжтой буюу хангалттай даацтай байх;
4. Гадна хана нь чийггүй, хуурай байх;
5. Цахилгааны кабель, утас, усны шугам хоолой, агаар сэлгэлтийн нээлхийг дулаалгын материалаар далдлахын өмнө сайтар шалгах
6. Өрөгт бүтээцтэй барилгыг хөөсөнцөр болон эрдэс хөвөнгийн аль алинаар дулаалах боломжтой бол модон барилгыг зөвхөн эрдэс хөвөн ашиглаж агаар сэлгэлттэй технологиор дулаална

ДОТОР ТАЛААС ДУЛААЛАХАД

1. Дулаалга хийснээр барилгын дотор талын ашигтай орон зай багасна
2. Байшингийн насжилт багасна
3. Дулаалга хийгдэж байх хугацаанд бригадыг ажиллах нөхцөлөөр хангаж сууцаа чөлөөлөх
4. Аюулгүй ажиллагааг хангах


СУУРИЙН ДУЛААЛГА

Эрчим хүчний хэмнэлт

10%

Хийгдэх хугацаа

04/15 - 10/15



ДУЛААЛГЫН ТЕХНОЛОГИ

1. Бетон суурь /Ус чийгээс хамгаалах түрхлэгтэй/
2. Дотор цавуут зуурмаг
3. XPS дулаалгын хавтан 10см
4. Бэхэлгээ хадаас
5. Гадна цавуут зуурмаг
6. Керамик хавтан/шавардлага
7. Усны хаялга төмөр

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Суурийн бетон хагарсан, бутарсан эсэх
2. Суурийн гадаргуу тэгш бус, жигд гөлгөр бус эсэх

2.3 ТҮГЭЭМЭЛ АШИГЛАГДДАГ ДУЛААЛГЫН МАТЕРИАЛУУД

Хүснэгт. Түгээмэл ашиглагддаг дулаалгын материалууд

Материал	Зураг	Дулаалгын зориулалт	Давуу талууд	Анхаарах зүйлс
Эрдэс хөвөн		Дээврийн адрын хөндий болон гадна хана	Амьсгалдаг, дулаан хадгалах чадвартай	Уур тусгаарлагчтай хамт хэрэглэх
Хөөсөнцөр		Гадна хана болон шал	Хямд, хөнгөн, дулаан тусгаарлалт сайн	Хорхой шавж үүрлэх, хөгц үүсэх эрсдэлтэй

Чулуун хөвөн		Дээврийн адрын хөндий болон гадна хана	Галд тэсвэртэй, дулаан хадгалалт сайн	Зөв суулгалт, уур тусгаарлалт чухал
Полиуретан хавтан-шүршдэг хөөс		Гадна хана, шал болон дээвэр	Зузаан, өндөр дулаан тусгаарлалттай	Үнийн хувьд өндөр

2.4 ДУЛААЛГЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ

Банкны ажилтан та амины орон сууц дулаалахад шаардлагатай бараа материалын үнэ ханшийн мэдээллийг сар бүр шинэчилснээр доорх Барилга.мн болон бусад сайт, платформуос цаг алдалгүй авах боломжтой.

barilga.mn

Barilga.mn → Барилгын үндсэн материал → Дулаан, дуу тусгаарлах материал

Цэс рүү орж дулаалга болон бусад барилгын материалын үнийг харах боломжтой.



Хүснэгт. Дулаалгын материалын үнэ (2025 оны 8 сарын 28-ны өдрийн байдлаар)

Материалын нэр	Марк/хэмжээ	Хэмжих нэгж	Үнэ/төгрөг/
Дулаалгын материал			
Полистрол EPS хавтан	(24-28кг/м³)	м³	200,000
Хөөсөн шахмал /XPS/ хавтан	XPS/3см/	м³	449,521
Эрдэс хөвөн		ш	140,000
Шилэн хөвөн	5см	м³	170,000-200,000
Чулуун хөвөн	5см-7.5см-10см	м³	30500-40,000
Эко ноос	5см	м³	209,000
Хонины ноосон дулаалга /Монгол/	5см-7.5см-10см	м²	27,500-37,500

Гялгар зөөлөвч дулаалга НПЭ	15м2 / 8мм наалддаг	м ²	160,000
Паркетны зөөлөвч дулаалга	50м2 / 2мм	м ²	68,000
Шахдаг хөөс	750мг	ш	18,000
Цонх	3 давхар шил	м ²	800,000-1,000,000
Фасадны төмөр	1220x2440x4	м ²	195,000-265,000
Өнгөлгөөний тоосго	M100	ш	3,000
Хулдаас	2-3мм зузаантай	м ²	25,000
Паркет	800x125x12мм	м ²	59,900
Хивсэнцэр	50x50см	м ²	54,000-64,000
Чийг тусгаарлах материал			
Гадар - ус чийг тусгаарлагч (ISOVER)	70м ²	м ²	145,000
Суурийн уур тусгаарлагч	70м ²	м ²	86,000
Хавтгай дээврийн уур ус тусгаарлагч	90м ²	м ²	121,000
Цаасан скоч	5мм өргөн	м	6,000
Мөнгөлөг скоч	2,5мм өргөн	м	7,000
Өнгөгүй наалт	2,5мм өргөн	м	10,000
Хуурай хольц/барилгын заслын материал			
Өнгөлгөөний цагаан замаска	25	кг	45,000
Барилгын ажилд хэрэглэх цавуу / хөөсөнцрийн цавуу	25	кг	13,000
Шал тэгшлэгч	25	кг	23,000
Элсэн замаск	25	кг	13,000
Силикон		ш	9,000
Силиконы буу		ш	7,000

2.5 ДУЛААЛГЫН ЖИШИГ ҮНИЙН МЭДЭЭЛЭЛ

Та доорх хүснэгтээс амины орон сууцны стандарт дулаалгын жишиг үнийн мэдээллийг харна уу.

Хүснэгт. Дулаалгын жишиг үнэ (2025 оны 9 сарын 16-ны өдрийн байдлаар)

Дулаалгын төрөл	Амины орон сууцны хэмжээгээр			
	6х6 (36м²)	6х8 (48м²)	8х8(64м²)	7х9 (63м²)
Дээврийн дулаалга (20 см)	1,800,000	2,350,000	3,080,000	3,040,000
Ханын дулаалга-хөөсөнцөр (15см)	6,200,000			8,030,000
Ханын дулаалга-эрдэс хөвөн (15см)		6,950,000	7,850,000	
Суурийн дулаалга (10см)	2,830,000	3,300,000	3,740,000	3,740,000
Гадна фасад- төмөр сайдинг		3,200,000	3,700,000	
Бүтэн дулаалгын үнэ /төгрөг/	10,830,000	15,800,000	18,370,000	14,810,000

Жич: Дээрх үнийг дундаж үнэтэй материалаар тооцсон ба дулаалгын үндсэн материал, туслах материал, ажлын хөлс, тээвэрлэлт зэрэг холбогдох бүх зардлыг оруулсан болно.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦНЫ ТӨРЛҮҮД




3.1 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦ

29

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэдэг нь Монгол орны эрс тэс уур амьсгалын нөхцөлд дотор орчны тав тух, эрүүл ахуйг хадгалах явцдаа эрчим хүчний хэрэглээг зохимжит хэмжээнд зарцуулахаар төлөвлөгдсөн амины орон сууцны бүтэц юм. Ийм сууцнууд нь дараах үндсэн зарчмуудыг баримталдаг:

- Өндөр үзүүлэлттэй дулаалгын материал: Өвлийн улиралд дулааны алдагдлыг мэдэгдэхүйц бууруулж, зуны улиралд хэт халалт орж ирэхээс сэргийлсэн үр дүнд нь жилийн турш эрчим хүчний хэмнэлт, дотор орчны тав тухыг нэмэгдүүлнэ.
- Ухаалаг архитектурын төлөвлөлт: Барилгын байрлал, зохион байгуулалт, цонхны чиглэл, нарны тусгалыг оновчтой ашиглан дулаан алдагдлыг багасгаж, байгалийн гэрэл, агаар сэлгэлтийг нэмэгдүүлнэ.
- Өндөр гүйцэтгэлтэй барилгын бүтээц: Чанартай дулаалгын материал, агаар нэвтрэхгүй бүтээц, дулааны гүүрийг бууруулах технологи ашиглан дулаан хадгалах чадварыг сайжруулна.
- Орчин үеийн инженерийн системүүд: Эрчим хүчний хэмнэлттэй халаалт, хөргөлт, агаар сэлгэлтийн системүүдийг суурилуулж, хэрэглээний эрчим хүчийг оновчтой болгоно.
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд: Нар болон салхины сэргээгдэх эрчим хүчний технологийг ашиглан уламжлалт эрчим хүчний хэрэглээг орлуулах буюу бууруулна.
- Үр ашигтай хэрэглээний дадал зуршил: Ухаалаг хяналтын систем, хэрэглээний мэдрэгчүүд, оршин суугчдын эрчим хүч хэмнэх дадал зуршлыг дэмжих замаар хэрэглээг оновчтой болгоно.



Зураг. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэж юу вэ?

3.2 ТЭГ ЗАРЦУУЛАЛТТАЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ СУУЦ

Тэг зарцуулалттай эрчим хүчний сууц гэдэг нь тухайн барилга нь жилийн турш хэрэглэдэг нийт эрчим хүчний хэмжээг өөрөө үйлдвэрлэж, гаднаас нэмэлт эрчим хүч авахгүйгээр өөрийн хэрэгцээг бүрэн хангах чадвартай, өндөр үр ашигтай архитектурын шийдэл бүхий барилга юм.

- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглалт: Нарны эрчим хүчний хавтан, салхин турбин зэрэг сэргээгдэх эх үүсвэрүүдийг ашиглан цахилгаан болон дулааны эрчим хүчийг үйлдвэрлэнэ.
- Дулаан алдагдлыг бууруулсан барилгын хийц: Барилгын дулаан тусгаарлалт, агааржуулалтын системийг сайжруулж, дулааны насос зэрэг эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмжүүдийг ашигласнаар дулааны алдагдлыг хамгийн бага түвшинд барина.
- Эрчим хүчний хэмнэлттэй архитектурын шийдэл: Байгалийн гэрлийг үр ашигтай ашиглах, барилгын байрлал, цонхны чиглэл зэргийг оновчтой төлөвлөх замаар эрчим хүчний хэрэглээг бууруулна.
- Нүүрстөрөгчийн ялгарлыг багасгах: CO₂ болон бусад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, байгаль орчинд ээлтэй, тогтвортой амьдрах орчин бүрдүүлнэ.



“Эрчим хүчний тэг зарцуулалттай сууц”-ны талаар шийдэл болон системийн төлөвлөлтийн мэдээллийг ШУТИС-ийн дэргэдэх БЭХХТөвийн Дулаан Шийдэл II төслийн хүрээнд гүйцэтгэсэн сууцны барилгын танилцуулгыг “БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН АМИНЫ ОРОН СУУЦЫГ ДУЛААЛАХ ТЕХНОЛОГИ”-ын гарын авлагаас харна уу.

Мөн энэхүү загвар сууц нь долоо хоног бүрийн лхагва гарагт олон нийтэд нээлттэй мэдээлэл өгдөг тул та бүхэн өөрийн биеэр зочлон танилцаж мэдээлэл авах боломжтой.

Хаяг: Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн ухааны сургууль (хуучнаар КТМС)-ийн хашаанд

Эрчим Хүчний Хэмнэлттэй Загвар Сууц	
	Загвар сууцны байршил заах QR холбоос 
Эрчим хүчний хэмнэлттэй Амины орон сууцны ажлын зураг төсөл татах QR холбоос. Та тус QR кодыг камераараа уншуулан ажлын зургийг үнэ төлбөргүй татаж авах боломжтой.	Ажлын зураг төсөл татах QR холбоос 

ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН




4.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ДУЛААЛГЫН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭХ НЬ СУДАЛГАА, 2025 ОН

Энэхүү судалгаанд Банк бус санхүүгийн байгууллагаас өрхийн зээл авах хүсэл сонирхол, нөхцөлийн талаарх санал бодол, зээл олгогчдын болон ББСБ-ын төлөөлөгчдийн байр суурь, тулгамдаж буй бэрхшээл, Монголын зах зээл дэх дулаалгын зээлийн орчин, мөн олон улсын туршлага зэргийг хамруулсан.


СУДАЛГААНЫ ТОЙМ



Хүсч буй зээлийн хугацаа / сараар/



Дулаалгын зээл хүсэх тохиромжтой сар



ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮЛЭЭЛТ

Иргэд дулаалгын зээлийг дараах нөхцөлтэй байх нь зохимжтой гэж үзсэн:

- Сарын хүү 0.5–2.5%
- Зээлийн хугацаа 24–36 сар
- Зээлийн хэмжээ 10 сая төгрөг хүртэл
- Барьцаа, урьдчилгаа бага буюу шаардахгүй байх

ББСБ-УУДЫН АШИГ, СОНИРХОЛ

- ББСБ-уудын Холбоо 2030 он гэхэд нийт зээл олголтын 5%-ийг байгальд ээлтэй зээлээр бүрдүүлэхээ амласан нь ногоон санхүүгийн стратегитай нийцэж байгааг харуулж байна.

ӨРХИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГААР БАТАЛГААЖИВ

- Өрхүүд дулаалга хийх өндөр эрэлт шаардлага байгааг бүлгийн ярилцлагаар баталгаажуулсан бөгөөд зээлийн шалгуур, санхүүгийн боломж хоёр нь хамгийн том сорилт гэж тодорхойлсон.
- Өрхүүд шаталсан байдлаар дулаалга хийх сонирхолтой бөгөөд зээлийн бүтээгдэхүүн нь дулаалгаас гадна засвартай хамт багцлагдсан байвал илүү эрэлттэй байна гэж үзсэн.
- Өрхүүд өөрсдөө дулаалга хийх сонирхол байдаг хэдий ч, хэрхэн яаж хийх талаар мэдээлэл байдаггүй.

ҮР ДҮНТЭЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС СУРАЛЦАХ НЬ

- Зээлийн уян хатан нөхцөл – Австрали, Их Британи, АНУ-ын жишээнээс суралцахад эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний ногоон зээл нь хүүгийн хөнгөлөлттэй, урьдчилгаагүй, 100 хувь санхүүжилт олгож байгаа нь хүртээмжийг нэмэгдүүлж байна.
- Харилцагч төвтэй эргэн төлөлт – Шаталсан зээл олголт нь дулаалгын нийт өртгийг дулаалга хийх цаг хугацаатай уялдуулж бага багаар олгох бөгөөд ингэснээр зөвхөн олгогдсон мөнгөн дүнд зээл бодогдох юм. Мөн эхний жилд зөвхөн хүүгийн төлөлт хийх боломж олгож, эрчим хүчний хэмнэлттэй уялдуулсан эргэн төлөлт санал болгож байгаа нь айл өрхүүдэд учруулах санхүүгийн ачааллыг бууруулж байна.
- Итгэлцлийг бий болгох нь – Нэг цэгийн үйлчилгээ, чадварлаг инженерийн дэмжлэг, ил тод цахим үйл явц нь харилцагчдын итгэлийг нэмэгдүүлж, ногоон зээл авах сонирхлыг нэмэгдүүлдэг.

Энэхүү судалгааны дэлгэрэнгүй тайланг үзэхийг хүсвэл www.dulaalga.mn → Амины Орон Сууцны Дулаалгын Шийдэл → Судалгааны тайлан цэс рүү орж аваарай.

4.2 ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ МОНГОЛЫН НОГООН САНХҮҮГИЙН КОРПОРАЦЫН(МНСК) “ИНСТИТУЦИЙН МЭДЛЭГ ӨВЛҮҮЛЭХ БАГЦ”

“Дулаан шийдэл-2” төслийн хүрээнд (2022–2026) МНСК-ийн хуримтлуулсан туршлага, сургамж, нөлөөллийн үйл ажиллагааны ололт амжилт, техникийн оролцоо болон амины орон сууцны дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны ногоон зээлийг дэмжихэд оруулсан хувь нэмрийг нэгтгэсэн **“Мэдлэг өвлүүлэх багц”**-ыг боловсрууллаа.

Энэхүү баримт бичиг нь төрийн байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөгжлийн түншүүд болон ногоон санхүүгийн өргөн хүрээний оролцогч талуудад зориулсан лавлах материал бөгөөд тогтвортой орон сууцны санхүүжилтийг цаашид өргөжүүлэх, бодлогын яриа хэлэлцээг дэмжих, туршлагыг нутагшуулахад ашиглагдана.

Та бүхэн энэхүү багцаас дараах мэдээллийг авах боломжтой. Үүнд:

- Улаанбаатар болон Дархан хот дахь ногоон зээлийн эрэлтийн судалгааны үр дүнд хийсэн шинжилгээ
- Эрчим хүчний хэмнэлттэй (ЕЕ) орон сууцны зардал–үр ашгийн шинжилгээнд хийсэн дүгнэлт
- ESG шаардлагад нийцэх шалгуур үзүүлэлттэй холбоотой судалгааны тойм, дүгнэлт
- 2022–2025 онд МНСК-иас боловсруулсан ногоон санхүүгийн механизм, холбогдох судалгааны материалын нэгтгэл
- 2022–2025 оны хугацаанд хэрэгжүүлсэн нөлөөллийн албан бичиг, цахим шуудан, бодлогын зөвлөмж, семинарын тэмдэглэл болон техникийн баримт бичгийн эмхэтгэл.

Энэхүү судалгааны дэлгэрэнгүй тайланг үзэхийг хүсвэл www.dulaalga.mn → Амины Орон Сууцны Дулаалгын Шийдэл → Судалгааны тайлан цэс рүү орж аваарай.

ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ



5.1 ДУЛААЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ (БРИГАД)-ТАЙ ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛЛ

Амины орон сууцыг дулаалах ажил нь зөв технологи, чанартай гүйцэтгэл хоёрын нягт уялдаанд тулгуурладаг. Тиймээс дулаалгын чиглэлээр сургагдсан, туршлагатай бригадаар дулаалуулах, хянуулах нь дулаан алдагдлыг бууруулах, дулаалгын чанарыг сайжруулахад чухал нөлөөтэй. Дулаан шийдэл төслийн хүрээнд амины орон сууц дулаалах чиглэлээр жижиг, дунд бизнес эрхлэгчдийг сургаж, дадлагажуулсан ба эдгээр дулаалгын бригадуудтай хамтран ажиллахаар сонирхож байгаа бол доорх холбоосоор нэвтрэх эсвэл QR кодыг уншуулан уу.



Зураг. Дулаан Шийдэл төслийн хүрээнд сургагдсан барилгын жижиг дунд бизнес эрхлэгчид



dulaalga.mn → Дулаалгын Зөвлөх

Цэс рүү орж дулаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулагч жижиг дунд бизнес эрхлэгчдийн мэдээллийг авах боломжтой.



Дулаалгын үндсэн материал нийлүүлэгч компаниуд

Хүснэгт. Дулаалгын үндсэн материал нийлүүлэгч компаниудын мэдээлэл

Д/д	Дулаалгын үндсэн материал нийлүүлэгч	Дулаалгын материалын төрлүүд	Холбоо барих QR код
1	 Эко вүүл ХХК Хонины ноосон дулаалга	Хонины ноосон дулаалга	
2	 Монгол Базальт ХК	Чулуун хөвөн (Базальт вүүл)	
3		"Евро Базальт" эрдэс чулуун хөвөн	
4	 Росторг ХХК	Эрдэс хөвөн (Экоролл Росторг) Эрдэс хөвөн хавтгай 0.40 (Кнауф Росторг) Эрдэс хөвөн хавтгай 0.37 (Кнауф Росторг) XPS хөөсөнцөр хавтан Хуванцар-польш сайдинг Хуванцар-орос шинэ сайдинг Төмөр сайдинг	
5	 Гэгээн өргөө ХХК	Америк эрдэс хөвөн Америк чанар- Дулаалгын эрдэс хөвөн	
6	 Пирамид индастри ХХК	EPS хөөсөнцөр хавтан 21-22кг	

7	 Старвиндов ХХК	SHIDE брэндийн дуу, эрчим хүчний хэмнэлттэй 3 давхар шиллэгээтэй цонх	
		Герман тоноглолтой, эрчим хүчний хэмнэлттэй 3 давхар шиллэгээтэй цонх	
8	 Бингл Спид ХХК	SHIDE брэндийн дуу, эрчим хүчний хэмнэлттэй 3 давхар шиллэгээтэй цонх	
9	 Баялаг хөөс ХХК	EPS хөөсөнцөр хавтан-Кунаф	

5.3 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦ ГҮЙЦЭТГЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэдэг компаниудын мэдээллийг энд багтаав. Эдгээр компаниуд нь орчин үеийн технологи, стандартын шаардлагад нийцсэн материал ашиглан эрчим хүчний хэрэглээг бууруулах, тав тухтай орчныг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба холбоо барих мэдээллийг орууллаа.

№	Компанийн нэр	Тайлбар	Холбоо барих
1	 Hybrid House LLC	Хайбрид хаус ХХК Өрөгт бүтээцтэй	 8810-6942
2	 ГРАНД АВГУШ БАЙРГА УГСРАТ	Гранд Авгуш ХХК Өрөгт бүтээцтэй Барилга угсралт, дотоод засал чимэглэл, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц угсралтын компани	 9905-9464
3	 ISOHAUS	Изо Хаус ХХК Арагт бүтээцтэй Герман стандартын амины орон сууц	 7575-9009

4		Ай Мэйдал ХХК Өрөгт бүтээцтэй Enso Village Passive House	 8006-2299
5		Эрдэнэс Түмэн Хаус ХХК Хаусны цогц шийдэл болон эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууц барьдаг.	8030-3344, 9111-9608
6		Түшигт хот хаус ХХК Өрөгт бүтээцтэй	 9007-8486
7		Пассив Хаус Монголын анхны Пассив Хаус зөвлөх дизайнер, EDGE ногоон барилгын зөвлөх, EDGE advanced сертификаттай	 8980-8980
8		Зебра хаус ХХК Барилгын материалын худалдаа Барилгын материал үйлдвэрлэл Барилга угсралт	 7711-0707
9		Воркмастер ХХК Арагт бүтээцтэй Барилга угсралт, Интерьер зураг төсөл гүйцэтгэл, тавилга үйлдвэрлэл.	 9923-2628, 9977-1178
10		Тимхас хаус ХХК Арагт бүтээцтэй	 9912-0545
11		БӨ ОМ инженеринг ХХК Өрөгт бүтээцтэй	 9191-5952, 9192-5952



12	 ОТ ЦА МИ ХХК	От Ца Ми ХХК Арагт бүтээцтэй	 9970-0730
13	 Шинэлэг сууц ТАВ ТУХЫГ БҮТЭЭНЭ	Шинэлэг сууц ХХК Арагт бүтээцтэй	 9191-6240, 9101-6240
14		ЭЭДБ ХХК Өрөгт бүтээцтэй Энержи Эффишент Дизайн Бюлд (ЭЭДБ) компанийн эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны шийдэл	 8586-5511
15	 БОЁД —КОНСТРАКШ—	Боёд констракшн ХХК Өрөгт бүтээцтэй	 7777-7779

5.4. БАРИЛГЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТОРУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Барилгын салбарт “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Эрчим хүчний зохицуулах хороо”-оос зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, бие даан болон байгууллагын түвшинд эрчим хүчний аудитын үйл ажиллагаа явуулах эрх бүхий аудаторуудын эрх олгосон огноо, үйл ажиллагааны чиглэл, холбогдох мэдээллийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эрчим хүчний зохицуулах хорооны цахим хуудасны <https://ecc.erc.gov.mn/mn/m/83> холбоосоор авах боломжтой.

Эрх бүхий эрчим хүчний аудаторуудын мэдээллийг <https://ecc.erc.gov.mn/mn/m/83> цахим хуудаснаас үзэх боломжтой. QR холбоос →





ХАЯГ: Монгол улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Делта төв, 403 тоот.

☎ (976) 7505 2000
🌐 dulaalga.mn
📱 дулаан шийдэл төсөл